

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар: 06

Улаанбаатар хот

Гамшгийн эрсдэлийг бууруулах,
мэргэжлийн байгууллагатай хамтран
ажиллах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 51 дүгээр зүйлийн 51.2, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар монгол орны нийт нутгаар цас их орсноос шалтгаалж, зудын нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул зудын гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажилласугай.

2. Зудын гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахад зарцуулах 300,000,000 (гурван зуун сая) төгрөгийг “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2024 оны батлагдсан төсвийн байгалийн гамшиг, ослын үр дагаврыг бууруулах зардлаас гаргаж зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг, зудын гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж ажиллахыг, хийсэн ажлын талаарх тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ